# БАГШИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ЭЦСИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХИ НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН ТАНИЛЦУУЛГА

2018 оны 06 дугаар сарын 26-ны өдөр | Улаанбаатар хот

**Илтгэгч:Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Ж.Энхбаяр нараас Улсын Их Хуралд 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Тус Байнгын хороо 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийлээ.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23.2.1-д заасны дагуу нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийн зарим хэсэг, заалтыг гүйцээн боловсруулах чиглэлийг хуралдаан даргалагчаас өгсний дагуу ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураасныг Байнгын хорооны гишүүд дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хуулийн төслүүдийн холбогдох зүйл, хэсэг, заалтад нэмж тусгаснаас гадна хууль зүйн техникийн талаас нь хянан үзэж, үг хэллэг, найруулгын шинжтэй засвар, өөрчлөлтийг хийсэн хуулийн төслийг зарчмын зөрүүтэй саналын томьёолол, Байнгын хорооноос гаргасан танилцуулгын хамт Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл, зарчмын зөрүүтэй саналын томьёолол болон Байнгын хорооноос гаргасан танилцуулгыг хэлэлцэж, хуулийн төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА** **Ё.БААТАРБИЛЭГ**

Нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт
2018.06.26

# БАГШИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХИ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

**Нэг.Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дэмжсэн санал:**

**1.**Хуулийн төслийн 3.1.1 дэх заалтын "төрийн үйлчилгээний албан хаагчийг" гэснийг "этгээдийг" гэж өөрчлөх.

**Санал гаргасан:Байнгын хороо**

**2.**Хуулийн төслийн 3.1.4 дэх заалтын "хөгжил," гэсний дараа "хүмүүжил," гэж нэмэх.

**Санал гаргасан:Байнгын хороо**

**3.**Хуулийн төслийн 6.1 дэх хэсгийн "ёс зүй," гэсний дараа "эрүүл мэнд, нийгмийн баталгаа, багшийн үнэлэмжийг нэмэгдүүлэх" гэж нэмэх.

**Санал гаргасан:Байнгын хороо**

**4.**Хуулийн төслийн 21.1 дэх хэсгийн "Төрийн албаны тухай" гэсний дараа "болон Хөдөлмөрийн тухай хуульд" гэж нэмэх.

**Санал гаргасан:Байнгын хороо**

**5.**Хуулийн төслийн 18.1 дэх хэсгийн "чиг үүргийг" гэснийг "эрх, үүрэг" гэж өөрчилсөнтэй холбогдуулж бусад зүйл, хэсэг, заалтыг жигдлэх.

**Санал гаргасан:Байнгын хороо**

**Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо**

Төсөл
Нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт
2018.06.26

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар сарын … -ны өдөр | Улаанбаатар хот

## ~~БАГШИЙН ХӨГЖЛИЙН ТУХАЙ~~
## БАГШИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

~~1.1.Энэ хуулийн зорилт нь багшийн хөгжил, оролцоог дэмжих, нийгэмд эзлэх байр суурь, нийгмийн баталгаа хангах, багшийн мэргэжлийн ёс зүй, нэр төрийг сахихад багш, төрийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг, хүлээх хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.~~

**1.1.Энэ хуулийн зорилт нь багш бэлтгэх, багшийн хөгжил, оролцоог дэмжих, ёс зүй, нэр хүнд, нийгмийн баталгааг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.**

**2 дугаар зүйл.Багшийн хөгжлийг дэмжих ~~тухай~~ хууль тогтоомж**

2.1.Багшийн хөгжлийг дэмжих ~~тухай~~ хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль ~~тогтоомжийн бусад актаас~~ тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**

~~3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:~~

~~3.1.1."багш" гэж Боловсролын тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээж буй этгээдийг;~~

~~3.1.2."багшийн хөгжил" гэж мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвараа тасралтгүй нэмэгдүүлэх, орчин үеийн сургалтын дэвшилтэт арга барилыг сургалтад ашиглах, суралцагчдад хүмүүжил, төлөвшил, мэдээллийн үнэн зөвийг ялгах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, бүтээлчээр сэтгэх, шүүмжлэн эргэцүүлэх чадварыг олгох чадамжийг;~~

[1] Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

~~3.1.3."багшийн хөгжлийн төв" гэж багш ажлын байран дээр хөгжихөд шаардлагатай материал, тоног төхөөрөмж бүхий танхимтай боловсролын байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг;~~

~~3.1.4."багшийн ажил гүйцэтгэлийн үнэлгээ" гэж багшийн сурган хүмүүжүүлж буй нийт суралцагч, түүний эцэг эх, асран хамгаалагчийн сэтгэл ханамж, сурлагын амжилт, чанар, заах аргын чадвар, өөрийгөө хөгжүүлсэн байдал зэрэгтэй уялдсан багшийг үнэлэх системийг.~~

**3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:**

**3.1.1."багш" гэж Боловсролын тухай хуулийн[2] 44 дүгээр зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээж байгаа төрийн үйлчилгээний албан хаагчийг;**

**3.1.2."багшийн хөгжил" гэж багшийн мэдлэг, арга зүй, ур чадвар, боловсролоо дээшлүүлэх тасралтгүй үйл явцыг;**

**3.1.3."багшийн хөгжлийн төв" гэж багш ажлын байран дээрээ тасралтгүй хөгжихөд шаардлагатай хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж бүхий орчинг;**

**3.1.4."багшийн ажлын гүйцэтгэл" гэж суралцагчийн хөгжил, төлөвшил, хандлага, ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан бусад чиг үүргийн хүрээнд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээгээр илэрхийлэгдэх үр дүнг;**

**3.1.5."ерөнхий боловсролын сургуулийн туслах багш" гэж багшийн мэргэжлээр төгссөн, сургалтын үйл ажиллагаанд багшид туслах үүрэг бүхий этгээдийг;**

**3.1.6."боловсролын салбарын мэдээллийн систем" гэж бүх шатны боловсролын сургалтын байгууллага, сургалтын орчин, сургалтын үйл явц, үр дүн, салбарын хүний нөөц, суралцагчийн мэдээллийг бүртгэх, тайлан, мэдээ боловсруулах, хяналт тавих зориулалт бүхий программ хангамж, сүлжээний дэд бүтэц болон техник хангамжийн нэгдлийг /цаашид "систем" гэх/.**

~~**4 дүгээр зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**~~

~~3.1.Энэ хууль Монгол улсын боловсролын салбарт ажиллаж буй дараах багш нарт үйлчилнэ. Үүнд:~~

~~3.1.1. Сургуулийн өмнөх боловсролын салбарт ажиллаж буй багш~~
~~3.1.2. Бага, дунд боловсролын салбарт ажиллаж буй багш~~
~~3.1.3. Мэргэжлийн боловсролын салбарт ажиллаж буй багш~~
~~3.1.4. Дээд боловсролын салбарт ажиллаж буй багш~~

**4 дүгээр зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

[2] Боловсролын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 19 дугаарт нийтлэгдсэн.

4.1.Энэ хууль нь өмчийн хэлбэр харгалзахгүйгээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа бүх шатны албан болон албан бус боловсролын сургалтын байгууллагад ажиллаж байгаа багшид үйлчилнэ.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ
## БАГШИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТОГТОЛЦОО

~~5 дугаар зүйл.Төрөөс багшийн хөгжлийг дэмжих чиглэл~~

~~5.1.Төрөөс багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг дараахь хэлбэрээр зохион байгуулна:~~

~~5.1.1.багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр;~~
~~5.1.2.багшийн хөгжлийг дэмжих төлөвлөгөө;~~
~~5.1.3.багшийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааны модуль;~~
~~5.1.4.багшийн хөгжлийн төв.~~

5 дугаар зүйл.Төрөөс багшийн хөгжлийг дэмжих тогтолцоо

5.1.Багшийн хөгжлийг дэмжих тогтолцоо нь багш бэлтгэх, багшийн мэргэжлийг дээшлүүлэх, давтан бэлтгэх, ажлын байран дээр тасралтгүй хөгжих үйл явцын нэгдэл байх бөгөөд багшид үндэсний, орон нутгийн, байгууллагын, сонирхлын бүлгийн, багшийн түвшинд дэмжлэг үзүүлнэ.

5.2.Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг үндэсний түвшинд багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн байгууллага, орон нутгийн түвшинд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, байгууллагын түвшинд захирал, сургалтын менежер, эрхлэгч, арга зүйч, сонирхлын бүлгийн түвшинд хамтын удирдлагын нэгдэл, багш өөрөө хэрэгжүүлнэ.

6 дугаар зүйл.Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр

~~6.1.Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр нь багшийн мэдлэг боловсрол, ур чадвар, хандлагыг суралцагчдад олгох шаардлагатай арга хэмжээ, үйл ажиллагааны цогц байх бөгөөд энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагааны хэлбэрүүдтэй байж болно.~~

6.1.Багшийн мэдлэг, боловсрол, хандлага, ёс зүй, мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөртэй байна.

6.2.Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг Засгийн газар батална.

~~7 дугаар зүйл.Багшийн хөгжлийг дэмжих төлөвлөгөө~~

~~7.1.Аймаг, нийслэлийн боловсролын газар нь тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийг хөгжүүлэх төлөвлөгөөг багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөртэй уялдуулан баталж, хэрэгжүүлнэ.~~

~~7.2. Бүх шатны боловсролын өөрийн удирдлага нь Багшийг хөгжүүлэх төлөвлөгөөг багш бүрийн саналд үндэслэн тухайн нутаг дэвсгэрийн төлөвлөгөөтэй нийцүүлэн баталж, хэрэгжүүлнэ~~

~~7.3.Төрийн өмчийн бүх шатны боловсролын байгууллагын багш нарын зөвлөл нь багшийн хөгжлийн төлөвлөгөөндөө үндэслэн шаардлагатай материал, сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалт, боловсролын ахисан түвшиний сургалтад хамруулах багшийн нэрс, шаардлагатай сургалтуудын захиалгыг бэлтгэн багшийн мэргэжил дээшлүүлэх, сургалт арга зүйн байгууллагад хүргүүлнэ.~~

**~~8 дугаар зүйл.Багшийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааны модуль~~**

~~8.1.Багшийг хөгжүүлэх сургалт, бусад үйл ажиллагааг багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт арга зүйн байгууллага явуулна.~~

~~8.2.Бүх шатны боловсролын байгууллага нь багшийн хөгжлийн төвөөрөө дамжуулан 8.1 д заасан байгууллагаас захиалгаар багшийг ажлын байран дээр хөгжүүлэхтэй холбоотой сургалт, бусад дэмжлэгийг авч болно.~~

~~8.3.Багшийг ажлын байран дээр хөгжүүлэхтэй холбогдсон зардлыг тухайн боловсролын байгууллагын төсвөөс санхүүжүүлнэ.~~

**~~9 дүгээр~~ 7 дугаар зүйл.Багшийн хөгжлийн төв**

~~9.1~~ 7.1.Бүх шатны боловсролын байгууллага нь багшийн хөгжлийн төвтэй байна.

~~9.2.Багшийн хөгжлийн төв нь багш ажлын байран дээр мэдлэг боловсролоо дээшлүүлэх, ур чадвараа хөгжүүлэх, мэргэших, давтан суурах, багш өөрийн мэдлэг боловсролоо тогтмол дээшлүүлэх, хөгжих таатай орчин байна.~~

~~9.3.Бүх шатны боловсролын байгууллагын удирдлага нь багшийн хөгжлийн төвөөр дамжуулан багшид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хөгжүүлэх үйл ажиллагааг явуулж болно.~~

~~9.4.~~ 7.2.Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт-арга зүйн байгууллага нь бүх шатны боловсролын байгууллагын багшийн хөгжлийн төвд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгнө.

~~9.5.Багшийн хөгжлийн төвийн хэвийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг тухайн боловсролын байгууллагын төсөвт жил бүр тусгана.~~

**~~9.5~~ 7.3.Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын нийт хувьсах зардлын хоёр хувь хүртэл хэмжээний зардлыг зарцуулна.**

**~~9.6~~ 7.4.Дээд боловсролын сургалтын байгууллага нь багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд зарцуулах зардлын хэмжээг тухайн сургуулийн Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулна.**

**~~9.7~~ 7.5.Багшийн хөгжлийн төвд тавигдах шаардлага, ажиллах үлгэрчилсэн журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.**

**~~10~~ 8 дугаар зүйл.Багшийг бэлтгэх**

~~10.1~~ 8.1.Орон нутгийн төрийн захиргааны байгууллага нь тухайн нутаг дэвсгэрийн багшийн эрэлт ~~хэрэгцээ, багшийг хөгжүүлэх төлөвлөгөөнд~~ **хэрэгцээнд** тулгуурлан захиалгаар багш бэлтгүүлэх гэрээг сургууль болон суралцагчтай байгуулж тэтгэлэг олгож болно.

~~10.2~~ 8.2.Засгийн газар хоорондын гэрээтэй орнуудад тэтгэлгээр сургах хөтөлбөрүүдийн тэргүүлэх чиглэлд багшийн мэргэжлийг ~~хамруулах зарчим баримтална~~ **хамруулна**.

~~10.3~~ 8.3.Багш мэргэжлээр дээд боловсрол олгох их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт 6 сарын хугацаатай дадлагажигч багшаар ажиллах агуулгыг багтаана. **Дадлагажигч хөдөө орон нутагт ажиллавал тэтгэлэг олгож болох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.**

~~10.4~~ 8.4.Ерөнхий боловсролын сургуулийн 44-өөс дээш хүүхэдтэй нэг, хоёрдугаар анги нь туслах багштай байж болно.

~~10.5~~ 8.5.Багш мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн төгсөгч нь багшлах эрхтэй байна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ
## БАГШИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ

~~**11 дүгээр зүйл.Төрөөс багшийн хөгжилд үзүүлэх дэмжлэг**~~

~~11.1. Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны хэлбэрүүд:~~

~~11.1.1.боловсролын ахисан түвшний сургалтад хамруулах;~~
~~11.1.2.багшийг судалгаа, эрдэм шинжилгээний төсөлд ажиллуулах;~~
~~11.1.3.гадаад, дотоодын ижил төрлийн сургуульд туршлага судлуулах;~~
~~11.1.4.багшийн мэдлэг боловсрол, ур чадварыг нэмэгдүүлэхэд шаардлагатай материал, хэрэгслээр хангах;~~

~~11.1.5.багшийн хөгжлийг дэмжих богино хугацааны сургалтад хамруулах.~~

~~11.2.Төрөөс багшийн мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, боловсролын бодлого, чиглэлийг таниулах, задлан шинжилж, нэгтгэн дүгнэх, бүтээлчээр сэтгэх, шүүмжлэлт эргэцүүлэх чадварыг нэмэгдүүлэх сургалтыг дараах байдлаар зохион байгуулна:~~

~~11.2.1. үндсэн сургалт;~~
~~11.2.2. төрөлжсөн сургалт;~~
~~11.2.3. ажлын байран дээрх сургалт;~~
~~11.2.4. цахим сургалт;~~
~~11.2.5. бусад.~~

~~**12 дугаар зүйл.Багшийн хувь хүний хөгжлийг дэмжих**~~

~~12.1.Бүх шатны боловсролын байгууллага нь ахмад үе, дунд үе, залуу үе хооронд туршлага солилцох, зөвлөн туслах, арга зүйн зөвлөгөө өгөх арга хэмжээг зохион байгуулж байна.~~

~~12.2.Бүх шатны боловсролын байгууллагын удирдлага нь багшийн сэтгэл зүй, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулж болно.~~

~~12.3.Ижил төрлийн боловсролын байгууллагууд нь харилцан туршлага солилцох зорилгоор 3 сар хүртэлх хугацаагаар багш солилцоо хэрэгжүүлж болно.~~

~~**13 дугаар зүйл.Багшийн оролцоо**~~

~~13.1.Бүх шатны боловсролын байгууллага нь багшийг мэдлэг боловсрол, ур чадвараа сайжруулах, өөрийгөө хөгжүүлэх талаар санал, хүсэлт гаргах боломжийг бүрдүүлнэ.~~

~~13.2.Багш нь боловсролоо дээшлүүлэх ур чадвараа сайжруулах талаар санал, хүсэлтээ сургуулийн захиргаа болон дээд шатны байгууллагад уламжилж болно.~~

~~13.3.Багш нь аймаг, нийслэлийн боловсролын газарт багшийн хөгжилтэй холбоотой гомдлыг шууд гаргаж болно.~~

~~13.4.Бүх шатны боловсролын байгууллагын багш нарын зөвлөл нь тухайн жилд багшийн хөгжилтэй холбоотойгоор зохион байгуулах, үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж, батална.~~

**~~14~~ 9 дүгээр зүйл.Багшийн нийгмийн баталгаа, хөгжил, оролцоог дэмжих, хангах**

**~~14.1~~ 9.1.Багш нь Төрийн албаны тухай хуулийн[3] 27.1-д заасан төрийн албан хаагчийн баталгаа, Боловсролын тухай хуулийн 43.1-д заасан нийгмийн баталгаагаар хангагдана.**

**~~14.2~~ 9.2.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн сургалт, боловсролын байгууллагын багшийн мэргэжлийн зэргийг суралцагчдын сурлагын амжилт, чанар, суралцагч, эсвэл түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн сэтгэл ханамж, заах аргын чадвар, өөрийгөө хөгжүүлсэн байдлыг харгалзан хугацаанаас өмнө нэмэгдүүлж болох бөгөөд холбогдох журмыг боловсролын болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.**

**~~14.3~~ 9.3.Багш мэргэжлээр төгсөгчийн мэдээллийг төгсгөсөн сургууль нь боловсролын салбарын мэдээллийн системд илгээнэ.**

**~~14.4~~ 9.4.Багшийг хөгжүүлэх үйл ажиллагаа нь багш мэргэжил эзэмшсэн хугацаанаас тооцогдох бөгөөд Боловсролын тухай хуулийн ~~40 дүгээр зүйлийн~~**

[3] Төрийн албаны тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

**40.8 дахь хэсэгт заасан багшийн мэргэжлийг дээшлүүлэх сургалтад хамрагдах үндэслэл болно.**

**~~11.5~~ 9.5.Энэ хуулийн ~~11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт~~ 9.4-д заасан хугацаанд багш сургалтад хамрагдаагүй тохиолдолд зардлыг өөрөө хариуцна.**

**~~12~~ 10 дугаар зүйл.Багшийн оролцоо**

**~~12.1~~ 10.1.Багш нь хувь хүний санаачилга, бүтээлч үйл ажиллагаанд суурилсан бие дааж хөгжих богино, дунд, урт хугацааны төлөвлөгөөтэй байна.**

**~~12.2~~ 10.2.Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын багш мэдлэг боловсрол, ур чадвараа сайжруулах, өөрийгөө хөгжүүлэх талаар холбогдох мэргэжлийн байгууллагад санал, хүсэлт, гомдол гаргаж болно.**

**~~12.3~~ 10.3.Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын багш зорилго, санаачилгаар нэгдэн сонирхлын бүлэг байгуулж, хамтран ажиллаж болно.**

**~~12.4~~ 10.4.Бүх шатны боловсролын сургалтын байгууллага, орон нутгийн боловсролын байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөтэй багш нь хувийн болон сонирхлын бүлгийн хөгжлийн төлөвлөгөөг уялдуулна.**

**~~13 дугаар~~ 11 дүгээр зүйл.Багшийн ажлын үр дүн**

**~~13.1~~ 11.1.Багшийн тухайн хичээлийн жилд ажилласан үр дүнгийн мэдээллийг боловсролын салбарын мэдээллийн системд боловсролын сургалтын байгууллага илгээнэ.**

**~~13.2~~ 11.2.Багш хувийн хөгжлийн төлөвлөгөөндөө тусгасан ажлын гүйцэтгэлийг боловсролын салбарын мэдээллийн системд өөрөө илгээнэ.**

**~~13.3~~ 11.3.Багшид ажлын гүйцэтгэлд суурилсан урамшууллыг олгох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.**

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
## ЁС ЗҮЙ~~, ХАРИУЦЛАГА~~, НЭР ХҮНД

**~~14 дүгээр~~ 12 дугаар зүйл.Ёс зүйн хороо**

~~14.1~~ 12.1.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дэргэдээ их, дээд сургуулийн багшийн ёс зүйн хороотой байна.

~~14.2~~ 12.2.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дэргэдээ мэргэжлийн боловсрол, сургалтын төвийн багшийн ёс зүйн хороотой байна.

~~14.2~~ 12.3.Аймаг, нийслэлийн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дэргэдээ ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн ёс зүйн хороотой байна.

~~14.3~~ 12.4.Бүх шатны боловсролын байгууллага нь тухайн байгууллагын багш нарын төлөөлөл бүхий **орон тооны бус** ёс зүйн зөвлөлтэй байна.

**~~15~~ 13 дугаар зүйл.Ёс зүйн дүрэм**

~~15.1~~ 13.1.Багшийн ёс зүйн хорооны дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

~~15.2~~ 13.2.Бүх шатны боловсролын байгууллагын ёс зүйн дүрэмд доорх асуудлуудыг заавал тусгасан байна.

~~15.2.1~~ 13.2.1.багшийн эрхэмлэх зүйлс;
~~15.2.2~~ 13.2.2.багшийн ёс зүйн хэм хэмжээ;
~~15.2.3~~ 13.2.3.ёс зүйн хариуцлага.

**~~16 дугаар~~ 14 дүгээр зүйл.Багшийн ёс зүйн хариуцлага**

~~16.1~~ 14.1.Суралцагч, түүний эцэг, эх, асран хамгаалагчийн зүгээс гаргасан гомдлыг тухайн байгууллагын ёс зүйн зөвлөл хүлээн авч шийдвэрлэнэ.

~~16.2~~ 14.2.Тухайн байгууллагын ёс зүйн зөвлөл нь ёс зүйн зөрчил гаргасан багшийн цалинг тодорхой хугацаагаар бууруулах, багшийн ажлын үр дүнгээс хамаарсан урамшууллыг хасах, сануулах зэрэг арга хэмжээ авах эрхтэй байна.

~~16.3~~ 14.3.Ёс зүйн зөвлөл нь ёс зүйн ноцтой зөрчил гаргасан багшийн асуудлыг холбогдох дээд шатны ёс зүйн хороонд хүргүүлнэ.

~~16.4~~ 14.4.Ёс зүйн хороо нь ноцтой зөрчил гаргасан, эсвэл ёс зүйн зөрчил удаа дараа гаргасан багшийн багшлах эрхийг хасаж, ажлы~~н байр~~наас чөлөөлж болно.

**~~ТАВДУГААР БҮЛЭГ~~**
**~~БАГШИЙН ХӨГЖЛИЙН БАТАЛГАА~~**

**~~17 дугаар зүйл.Багшийн хөгжлийн баталгаа~~**

~~17.1.Багш нь Төрийн албаны тухай хуулийн 27.1-д заасан төрийн албан хаагчийн баталгаа, Боловсролын тухай хуулийн 43.1-д заасан нийгмийн баталгаанаас гадна багшийн хөгжилтэй холбоотойгоор дараахь баталгаагаар хангагдана:~~

~~17.1.1.багшийн хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын байгууллага нь хамран суралцах тойргийн дагуу тэргүүн ээлжинд авна.~~

~~17.1.2.ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн мэргэжлийн зэргийг суралцагчдын сурлагын амжилт, чанар, суралцагч эсвэл түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн сэтгэл ханамж, заах аргын чадвар, өөрийгөө хөгжүүлсэн байдлыг харгалзан хугацаанаас өмнө нэмэгдүүлж болно.~~

~~17.1.3.багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан урамшууллыг багшид олгож болно.~~

~~17.1.4.багшийг жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулна.~~

~~17.2.Багшийн хөгжлийн баталгаанд шаардагдах хөрөнгийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.~~

## ~~ЗУРГАДУГААР~~ ТАВДУГААР БҮЛЭГ
## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

**~~18~~ 15 дугаар зүйл.Засгийн газрын чиг үүрэг**

~~18.1~~ 15.1.Засгийн газар дараахь ~~чиг үүргийг~~ **эрх, үүргийг** хэрэгжүүлнэ:

~~18.1.1~~ 15.1.1.багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг 5 жил тутам батлах;
~~18.1.2~~ 15.1.2.багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын ~~болон орон нутгийн~~ төсөвт тусгаж, ~~өргөн мэдүүлэх~~ **хэрэгжүүлэх**;

~~18.1.3~~ 15.1.3.хууль тогтоомжид заасан бусад.

**~~19 дүгээр~~ 16 дугаар зүйл.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүрэг**

~~19.1~~ 16.1.Боловсролын асуудал ~~хариуцсан~~ **эрхэлсэн** төрийн захиргааны төв байгууллага нь багшийн хөгжил, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

~~19.1.1~~ 16.1.1.багшийг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

~~19.1.2.боловсролын асуудал хариуцсан төв байгууллага нь жил бүр бүх шатны боловсролын байгууллагын багш, ажилчдын эрэлт хэрэгцээний судалгаанд үндэслэн энэ хуулийн 10.3-д заасан тоттоллгийг олгох;~~

~~19.1.3~~ 16.1.2.багшийг түрээсийн орон сууц, ипотекийн зээлд хөнгөлөлттэй нөхцөлтэйгээр хамруулах хөтөлбөрийг барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

**~~19.1.5~~ 16.1.3.боловсролын салбарын мэдээллийн цахим санг бүрдүүлэх;**

~~19.1.4~~ 16.1.4.хуульд заасан бусад.

**~~20~~ 17 дугаар зүйл.Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт-арга зүйн байгууллагын эрх, үүрэг**

**~~20.1~~ 17.1.Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт-арга зүйн байгууллага дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:**

~~20.1~~ 17.1.1.багшийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг жил бүр боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, батлуулах;

~~20.2~~ 17.1.2.Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт-арга зүйн байгууллага нь бүх шатны боловсролын байгууллагын багшийн хөгжлийн төвд мэдээлэл, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

~~20.3.Багшийг хөгжүүлэх талаар цахим мэдээллийн санг бүрдүүлж багшийн хөгжлийн төвүүдийг хангах~~

~~20.4~~ 17.1.3.багшийн хөгжлийн асуудлаар тогтмол судалгаа явуулах.

~~20.5.Багшийн хөгжилтэй холбоотой үзүүлэн, ном, товхимолыг тогтмол бэлтгэх;~~

~~20.6.Энэ хуулийн 11.2-д заасан сургалтыг өрөн далар зохион байгуулах;~~

~~20.7~~ 17.2.Багш мэргэжлээр их, дээд сургууль төгсөөгүй дээд боловсролтой төгсөгчдөд багшлах эрх олгох, сунгах шалгалтыг зохион байгуулна.

## ~~ДОЛДУГААР~~ ЗУРГАДУГААР БҮЛЭГ
## ХУУЛИЙН БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ

~~**21 дүгээр зүйл.Багшийн хөгжлийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих**~~

~~21.1.Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хууль тогтоомжоор эрх олгосон бусад байгууллага, албан тушаалтан эрх хэмжээнийхээ хүрээнд багшийн хөгжлийн баталгааны тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавина.~~

~~21.2.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ.~~

**~~21 дүгээр~~ 18 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

**~~21.1~~ 18.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтанд Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.**

~~21.3~~ 18.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

## ~~НАЙМДУГААР ЗҮЙЛ~~ ДОЛДУГААР БҮЛЭГ
## БУСАД ЗҮЙЛ

**~~22 дугаар~~ 19 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

~~22.1.Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.~~

**~~22.1~~ 19.1.Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.**

~~**ГАРЫН ҮСЭГ**~~

Гарын үсэг